

МОНГОЛ ХЭЛНИЙ ХАНДСАН ҮГИЙН ӨГҮҮЛБЭРЗҮЙ

Б.Пүрэв-Очир¹

*Гишүүд эз, нүдний шилээ зүүгээд, зүүн бүсийн ирээдүйг нэг харчихаарай.
("Зууны мэдээ" сонин, 2009, ¹ 280-аас)*

Хүн төрөлхтөн нь нэгдмэл нэг ертөнц, түүний орон зай, цаг хугацаа, тоо чанар, үйлдэгч ба хүлээн авагчийн харьцааг оюун ухаанаараа танин мэдэж, мэдэж авсан тэр зүйл буюу ертөнцийн зургаас үүтгэлтэй "үйл явдал", "хэрэг явдал"-ыг мэдээлж, өгүүлэгч-сонсогч, бичигч-уншигч гэсэн оролцогч биеүдийн харилцаанд тодорхой бүтэцлэгдсэн эмх цэгц бүхий мэдээллийг ямар нэгэн үнэлэмжтэйгээр дамжуулж харилцаж байдаг жамтай ажээ.

Үүнийгээ харилцахуйн болон өгүүлэхуйн түвшний үндсэн нэгжүүд болох санаа төгс эх ба утга төгс өгүүлбэрийн мэдэхүүний тал буюу хүн хийгээд хүний сэтгэлийн хөдөлгөөн, үнэлэмж, соёлын үнэт зүйлтэй холбон, шинжлэх ухааны ба ажиглах аргагүйгээр судалж тайлбарласаар иржээ.

Санаа төгс эх ба утга төгс өгүүлбэрээр мэдээлэл солилцоход харилцагч талууд ямар үүрэгтэй вэ, хэлэхуйн түвшин дэх дотоод ба гадаад ярианы хам хүрээнд бичил эх ба өгүүлбэрийн үүрэг – мэдээллийн бүтэц хэрхэн цогцолж, гишүүнждэг вэ, агуулга, хэлбэр нь хэрхэн яаж бүтдэг вэ? гэсэн асуудал бол олон хэлний нийтлэгийн хүрээнд, олон хэлтний харилцахуйн соёлд сонирхол татдаг зүйлийн нэг юм. Эл асуудлыг бүтэц хэлшинжлэлийн, сэтгэц-хэлшинжлэлийн, нийгэм-хэлшинжлэлийн, соёл-хэлшинжлэлийн, танихуйн хэлшинжлэлийн, угсаа-хэлшинжлэлийн г.м. олон өнцгөөс нь судалж тайлбарлаж болно.

Санаа төгс эхийг бүтээх, зохиомжлох, харилцахуйн түвшин дэх эх зохиогчийн үүрэг, хандлага, эхийн барилга байгууламжийн материал, хэрэглэхдэхүүн, харилцагч талуудын оролцоо, үнэлэмж, эх ба өгүүлбэрийн утга санаа, хэлбэржилтийг танин мэдэх, ухаарч ойлгох, үнэлж мэдрэх зэргийн цаана ганцаар ярианы (монолог), харилцаа ярианы (диалог), олон эзэнт ярианы (полилог) хам хүрээнд эх зохиогчийн хувийн шинж, дуудах аялга, аялгаар зааглах онцлох, харилцагчдын хүсэл зорилго, өнгө аяс, үнэлэмж зэрэгтэй олон талаар холбоотой оруулбар нэгжүүд, шууд ба шууд бус хөндлөнгийн үг, нэрлэсэн өгүүлбэр, догол мөрүүд, гарчиглахуй, цохолборлохуй, дүрслэг хэрэглүүрүүд, эхийн түлхүүр үгс, оноосон ба тусгай нэрийн сонголт, хэрэглээ, цэг цэглэл, хандсан үг, өгүүлбэр, эдгээрийн хэв маягууд г.м. цөөнгүй асуудлыг хамааруулан үздэг байна.

¹ Б.Пүрэв-Очир, МУБИС-ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, хэлшинжлэлийн шинжлэх ухааны доктор, профессор, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн.

Монгол хэлний оруулбар нэгжүүдийн өгүүлбэрзүй, цэг цэглэлийн өгүүлбэрзүй, **хандсан үгийн өгүүлбэрзүй нь**, нэрлэсэн өгүүлбэрийн өгүүлбэрзүй нь харьцангуй бага судлагдсан, цаашид тусгайлан судалмаар сэдвүүд юм гэж үзэж байна.

Хандсан үгийг нэг талаас нь харвал, бүтэц өгүүлбэрийн гаднах бүрэлдүүлбэр, нөгөө талаас авч үзвэл, тухайн эх, мөчлөг, цогцолбор, өгүүлбэрийн хэлэхүйн тал, мэдээллийн бүтцэд хамаатай, өгүүлэгч ба сонсогчийн харилцахууд холбогдох мэдэхүүний талын зүйл бөгөөд гол төлөв сэдэх мэдээллийн онцолборт хамаатай хандлага юм.

Монгол хэлшинжлэлийн бүтээлүүдэд хандсан үгийн талаар дурдаж тэмдэглэсэн зүйл мэр сэр байна. Эдгээрийг тоймлон харахад, нэг талаар, **“өгүүлбэрийн гишүүдтэй хэлзүйн холбогдолгүй үгс”** гэдэгт хамааруулж үзсэн, нөгөө талаар, зарим эрдэмтэн **хандсан үгийг аялга үг-өгүүлбэр, дуудах өгүүлбэртэй холбож үзсэн нь** (1) харагдаж байна. Тухайлж зарим баримтыг тодруулан дурдъя.

1966 оны хэлзүйд: “Өгүүлбэрийн үндсэн санаанд ямар нэг талаар тодруулах холбоо бүхий үгс... өгүүлбэрт хэлзүйн ямар ч холбоогүй, зөвхөн хэлэгч этгээдээс сонсогч этгээдийн анхаарлыг татахын тулд хэлсэн үг буюу бүлэг үгсийг хандсан үг гэнэ... Хандсан үг нь хэд хэдэн зүйл байдаг. Юуны өмнө, өгүүлэгч этгээдтэй харилцан бүхий сонсогч этгээд буюу 2-р биеийг шууд заан дуудсан нь элбэг байдаг...” (2:302) гэж дурдаад, хандлагын хэв маяг, хандсан үгийн байрлал, хандсан үгийг, бичигт цэг тэмдгээр ялгах тухай асуудалд илүү анхаарсан нь харагдаж байна. Тэгвэл акад. Ш.Лувсанвандангийн 1956 оны **“Монгол хэлний зүйн сурах бичиг”**-тээ: “Үг хэлэгч хэлэлцэж байгаа этгээдээ анхааруулах зорилгоор түүнд хандаж хэлсэн үг буюу холбоо бүхий үгсийг хандсан үг гэнэ... Хандсан үг бол нэрлэхийн тийн ялгалын хэлбэртэй, жинхэнэ нэрээр байна... Гэвч хандсан үг нь их төлөв **аа, ээ, оо, өө** гэж дуудах аялгуутай байх тул үгүүлэгдэхүүний нэрлэхийн тийн ялгалаас ялгавартай ажээ... Сэтгэл ихэд хөдлөн хэлэхэд хандсан үгийг давтан хэлэх удаа бий... Хандсан үг нь их төлөв хүний нэр, овог төрлийн нэр байдаг... Хандсан үгээр элэгсэг, энэрэлтэй, уур хилэнтэйн зэрэг санаа байдлыг цухуйлгаж бас болно... Хандсан үг бол ганцхан хүнд биш, мөн яруу найргийн зүйлд бол амьгүй зүйл, байгаль, уул усанд, хүнд хандаж хэлэхийн адил хэлсэн, бичсэн зүйл ч байдаг... (3:47-48) гэж бичжээ. Мөн тэрчлэн доц.Ш.Барайшир нарын 1989 оны “Өгүүлбэрзүй” гэдэг хамтарсан бүтээлд товч зүйлийг дурджээ.

Монгол хэлний **“Хандсан үгийн өгүүлбэрзүй”**-н гол асуудал бол харилцахуйн түвшин дэх түүний хэл, хэлэхүйн учир холбогдол, хамаатал, тогтолцоог тодруулах, өгүүлэгч ба хандлагыг сонсогч эзний харьцаа, хандсан үгийн хэвшинж, бүтэц, үүргийнх нь ерөнхий шинжийг тодорхойлон гаргах, санаа төгс эх, утга төгс өгүүлбэрийн мэдээллийн бүтцийн үүднээс монгол ухааны хандах үйлийн хэв маяг, хэрэглээний талыг тодосгон судлах, соёлын айтай холбоход оршино гэж үзэж байна.

Монгол хэлний **төрөл бүрийн найруулгад** хандсан үгийн хэрэглэгдсэн байдлыг ажиглаж, жишээ баримт задалж үзэхэд “Үүргийн найруулга”-ын дотроос **ярианы найруулга, уранзохиолын найруулгад** үлэмж **идэвхтэй хэрэглэгддэг, сонин нийтлэлийн болон албан хэргийн найруулгад хязгаарлагдмал байдлаар тохиолддог, харин эрдэм шинжилгээний найруулгад бараг хэрэглэгддэггүй** онцлогтой ажээ. Ер нь хандсан үг ба өгүүлбэр нь өгүүлбэрийн утгын бүтэц, ялангуяа мэдээллийн бүтцэд чухал үүрэгтэй бүрдэл хэсэг юм. Хандсан үг, дуудсан хандлагатай өгүүлбэрийг бүтэц өгүүлбэрт нэмэн оруулснаар тухайн өгүүлбэр нь агуулга, хэлбэрийн талаар дэлгэрч, **утга санаа** ба **мэдээллийн нэмэлт** ачаалалтай болдог гэж үзэж болно. Үүнийг:

Амьддаа бие биеэ хайрла, хүмүүс ээ!

Алив сайхнаа бусдаас битгий харамла. (О.Дашбалбар),

Поэт! Не дорожи любовью народной

Восторженных похвал пройдет минутный шум;

Услышишь суд глупца и смех толпы холодной:

Но ты останься тверд, спокоен и угрюм... (А.С.Пушкин),

Түмний хайранд бүү ташуур, **найрагч минь!**

Түр зуурын өргөмж, магтаалд бүү хуурт.

Тэнэгийн хэлэх, олны дооглох дуулдлаа ч

Тэвчээр зааж, тайван дүнсгэр бай! (Ц.Магсарын орчуулгаар)

гэсэн хоёр жишээг харьцуулан ажиглахад л монгол, орос хэлний хандлагын хэлбэр, дуудах аялга ба баймж, үнэлэмж, өгүүлэгч ба сонсогчийн харьцаа, соёлын зүйл, зан үйлийн ялгаа, хандсан үгийг байрлал зэрэг нь зурвас боловч харагдана. Бид хандсан үгийн, хамгийн их давтамжтай байгаа **уранзохиолын, ярианы** гэсэн гол хоёр чөлөөт найруулгын төрлөөс түүсэн баримтуудад ажиглалт хийгээд, монгол ухааны хандлагыг, мэдээлэхүй, хэлэхүйн учир холбогдол, ерөнхий шинж, хэв маяг, утга, үүргээр нь (А), (Б), (В), (Г) гэсэн дөрвөн бүлэгт хувааж болох үндэстэй байна гэж үзэв. Одоо эдгээр дөрвөн хэвшинжийг тус тус авч үзэж, бүтэц, утга, үүргээр нь тодруулъя. Ингэснээрээ баримтыг гол тулгуур болгож, “Монгол хэлний хандсан үгийн өгүүлбэрзүйн”-н судалгааг **арай шинэлэг аргаар хийж, тогтолцоог нь олж дүгнэлт гаргах** оролдлогыг хийсэн болно.

(А)

1. **Хүүхдүүд ээ!** өнөөдрөөс эхлэн би та нарт багшилна, хотод багшийн сургууль дөнгөж төгсөөд л танай энд ирлээ. (Л.Чойжилсүрэн),

2. **Чанцал минь,** Өвгөн чинь, малын хөлийн тоосонд дарагдаж, ганцаараа явсаар насыг баралтай биш. (С.Эрдэнэ),

3. **Чанцаал,** Саахалт чинь, агент хэвээрээ биз хө. (С.Эрдэнэ),

4. **-Өвгөөн!** Тос үнэртүүлэх гэсэн чинь, шар тос дуусчихжээ.

-Яахав яахав, **Хөгшөөн!** Шар тос байхгүй бол шөлний тос хийчихгүй юү дээ. (Д.Мягмар)

5. **Зулицэг ээ!** Би чамд үүнийг авчирсан юм гээд гараа сарвайлаа. (Ц.Балдорж),

6. **Хүн ард аа!** Би та нарт хайртай байсан юм шүү.

(Юлиус Фучик),

7. Сайн байна уу? **Оргодол гуай,** би судалгаа бүртгэлийн ажлаар, хороон даргын шийдвэрээр явж байна. (Д.Норов),

8. Академич **Ш.Лувсанвандан** танаа, ... Хүний оюун ухааныг эрдмээр гийгүүлэх нигүүлсэнгүй үйлсийн далайд хагас зуун шахам жил сал юугаа залсан өвгөн буурал багш аа!

Таны өлмий бат оршиж,

Хэлний хишгийг шавь нартаа

Ямагт даллаж байхын өлзийтэй сайхан

Ерөөлийг хичээнгүйлэн өчмүй. (МУИС, хэлбичгийн факультетийн хамт олон, 1980, I, 19)

9. **Ловон гуай,** Мядагийн өвчтэй хүүхэд нь эдгэрэх болов уу? (Ц.Дамдинсүрэн)

10. **Ай Цэцэг минь ээ!** Энэ бол би чамайг зодож буй хэрэг огт биш, энэ цөм хатан л чамайг зодож байгаа хэрэг юм. (Д.Нацагдорж);

(А-1-10)-д авч бүлэглэж үзсэн хандсан үгс ямар онцлогтой вэ? гэвэл:

а. (А-1-10)-д байгаа хэв маягийн хандсан үг нь өгүүлж буй зүйлд сонсогч биеийг харилцаанд татан оруулах, анхаарлыг нь “үйл явдал”, “хэрэг явдал”-д хандуулах зорилготойгоор оруулсан өвөрмөц нэгэн бүрэлдүүлбэр мөн.

б. Хандсан үгс нь дурдаж буй хэв маягт гол төлөв сав ба шим ертөнцийн юмны нэрийн (хүн, амьтан, ургамал г.м.) төрөл утгат үгсээр илэрдэг бодот юманд хандсан утга, зүй тогтолтой гэж үзэж болмоор байна. Жишээ нь: *Бумцэнд гуай!, Нөхөр хурандаа!, Дарга аа!* гэвэл хүн, хүний төрөлт нэрээр гэж үзэж болох талтай.

в. (А-1-10)-ын баримтаас харахад бүтэц өгүүлбэр нь өөртөө тусгай утгазүйн субъект, ба үйл эрхлэгч (агент)-тэй байгаа нь гол онцлог юм. Өөрөөр хэлбэл, хандсан үг нь тухайн өгүүлбэрийн үйлдэл, байдал, шинж заах өгүүлэхүүний эзний гадна илэрч, ямар ч холбогдолгүй байгаа. Ийм хэв маягийн хандсан үг нь учирзүйн талаас ч, утгазүйн талаас ч, хэлзүйн талаас ч бүтэц өгүүлбэрийнхээ *субъекттэй давхацдаггүй* тийм онцлогтой.

г. Энэ бол (А-1-10)-д байгаа маягийн хандсан үг нь бүтэц өгүүлбэрийнхээ хэлзүйн бүтцэд ямар ч холбогдолгүй байна гэсэн үг. Ийм хэв маягт бүтэц өгүүлбэрийн өгүүлэхүүн нь ер, бие заах (биеэр төгсгөх) нөхцөлөөр хэлбэрждэггүй. Хандсан үгийн дараа байрласан өгүүлбэрүүд нь гол төлөв хүүрнэх, асуух өгүүлбэрүүд (цагаар төгсгөх нөхцөлөөр хэлбэржсэн) байгаа нь бас л сонин зүйл байна. Жишээлбэл, Хавар ирлээ шүү, *Хүүхнүүд ээ!* гэсэн маягтай хэв маягууд зонхилдог зүй тогтолтой гэж үзэв.

д. Яригч ба бичигчийн сэтгэлийн хөдөлгөөн төдий л хүчтэй илрээгүй, харин найрсаг харьцаа, дуудах, анхааруулах аялга илэрч, оноосон ба тусгай нэрэнд авиалбарзүйн талаасаа үе уртассан байх нь олонт байна.

е. (А-8) жишээнээс харахад хандсан үг, түүний утгыг мэдээлэлд илүү онцолбол “давтан хэлэх” өвөрмөц зүй тогтол байдаг. Үүний баримт нь *Ах аа, Ах аа*, бие тэргүүтэй, дээл захтай нь сайн. (МНТ), *Ээ хөөрхий минь, морь минь, хүлэг минь*, одоо миний нуруун дээр юу ч байхгүй гэх шиг хальчихлаа даа. (До.Цэнджав) г.м-ээр түгээмэл тохиолддог.

ё. (А-1-10)-д буй хандсан үгсийг бүгдийг утга, үүргээр нь харилцахуйн түвшний “*идэвхтэй сонсон хүлээн авагч бие*” буюу “адресат” гэж үзэж болно.

ж. (А-1-10)-д байгаа тодорхой сэдэвт бичил эхээс авсан хандсан үгтэй өгүүлбэрүүдийг ажиглахад хандсан үг нь бүтэц өгүүлбэрийн доторх сэдэх мэдээллийн тэмдэг-үг болж, бараг ямар ч гишүүнтэй нь холбогдож чадахгүй юм. Иймд хандсан үгийн тэмдэг болох *чи, та*, г.м. хоёрдугаар бие буюу сонсогчийг төлөөлсөн үг уул бүтэц өгүүлбэрт тэгээр болон илээр орлон илэрч болохгүй байгаа юм. Энэ бол утгазүйн талаасаа хандсан үг нь энэ тохиолдолд үйл эрхлэгчтэй огт тохирохгүй, үйл ба үйлийн эзний идэвхтэй харьцааны гадна илэрдэг зүй тогтолтой гэж үзэж болно.

Одоо олонлогоороо (Б) бүлэглэлд хамаарах баримтыг авч үзэж, (А)-тай харьцуулбал сонин байж болмоор байна.

(Б)

1. *Дамбадорж оо, чи* Нэмэх хөвүүнийг хажуу өрөөнд оруулаад, бийр янтай зэхэж өг, мөнөөх түмэнд тунхаглан зарлах бичгийг хуулж сууг! (Д.Төрбат),
2. Унаж явсан муу хөх атны минь хөл доголчихжээ. *Дүү минь, чи* орон гаран харж байгаарай. (Д.Маам),

3. *Чанцаал*, маргааш манайд Дашинчилэнгийн хэдэн юм ирнэ. Газар газрынхантай ганзага нийлэх юу нь муу байхав. *Чи* заавал очоорой хө. (С.Эрдэнэ),
4. *Хуу минь, чи* сонсож байна уу? Энэ урд хоолойд орсон буурын шүд тачигнаж байхыг анзаардаг ч болоосой. (Д.Маам),
5. *Жамц минь, чи* сэтгэлээ барьж үз. (С.Эрдэнэ),
6. Саар хилэнцэт нөхрийн эрхэнд хэзээ ч үл багтах
Сайн хувийг хайрлагтун *та, Эгшигт эх ээ*. (Иштавхай),
7. *Хүүхдүүд минь, та нар* олигтойхон идэж ууж аваарай. (Д.Мягмар),
8. *Хөгшөөн! чи* наад бүсгүйгээ, чийггүй хуурай дов дээр амраагаач. (Д.Мягмар),
9. *Дорж минь, чи* хичээл номоо харахгүй явсаар шалгалтандаа унуузай. (Ж.Дамдин),
10. *Ээж минь, та* хүүгээ санахын цагтаа

Эгшиглэнт горхиныхоо уснаас амсаж нэг тайвшраарай. (Б.Алтангэрэл) г.м.

Төгс бичил эхүүдээс сонгож, (Б-1-10)-д авсан жишээ баримтаас үүтгэн, ямар дүгнэлт хийж болох вэ?

а. (Б-1-10)-д байгаа жишээ баримтын хандсан үг нь зорилгоороо, нэг талаар, өгүүлж буй зүйлд оролцох, сонсох хоёрдугаар бие болох утга заахын зэрэгцээ, нөгөө талаар, тухайн бүтэц өгүүлбэрийн үйлийг гүйцэтгэх, үйл эрхлэгч эзний (агент) холбогдолтой бүрэлдүүлбэр юм. Жишээ нь: *Нянгаа гуай, та* уураа тат гэхэд “*Нянгаа*” гэдэг оноосон нэр нь өгүүлэгчтэй харьцах, хандлагад өртөж, сонсогч хоёрдугаар бие-адресат болохын дээр, ...уураа татах... үйлийг гүйцэтгэх өртөн үйлдэгч болох утгыг зааж, мэдээлэлд чухалчлагдсан гэж үзэж байна.

б. (Б) хэв маягт, хандсан үгс нь төрөл утгат үгийнхээ шинжээр сав ертөнцийн юмыг ч зааж болох, шим ертөнцийн юмыг ч заасан байж болох хоёр талтай. Жишээ нь:

Магтаал алдар, эрх мэдэл ээ, чи

Мансууруулж, хүний үрсийг бүү хөнөө,

Магтаал, алдар, цол гуншин минь, чи

Мартагдаж, хэдийнэ талийсан хүмүүсийг л ивээ (Д.Цоодол)

гэсэн бичил эхэд хандсан үг нь нэрлэлтийн шинжээрээ сав ертөнцийн (нийгмийн) юмыг заасан нь харагдаж байна.

в. (Б-1-10) жишээний бүлгээс харахад, хандсан үгээр илэрч байгаа субъект нь ерөнхийдөө бүтэц өгүүлбэрийнхээ утгазүйн субъект, хэлзүйн өгүүлэгдэхүүнтэй давхцах шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, хандсан үг нь тухайн өгүүлбэрийн үйлдэл, хөдөлгөөн заах өгүүлэхүүнтэй ямар нэг талаар утгын холбогдолтой илэрч, үнэлэмжийн талаасаа албархаг өнгө аяс илэрхийлсэн онцлогтой юм.

г. (Б) хэв маягийн өгүүлбэрт хандсан үгийн араас байрласан бүтэц өгүүлбэрийн өгүүлэхүүн нь утгазүйн хувьд гол төлөв үйлдэл заах бөгөөд хэлзүйн хувьд хоёрдугаар биеэр төгсгөх Ø (тэг), –аарай, –гтун, –аач, –уузай, –аасай... г.м. нөхцөлөөр өгүүлэхүүн нь хэлбэржсэн захирах тушаах утгатай эсвэл хүсэл зоригийн утгатай өгүүлбэрүүд байгаа нэг өвөрмөц зүй тогтол ажиглагдав. Чухам тиймээс ч, хандсан үг нь тухайн өгүүлбэрийн субъект, нөгөө талаар, адресаттай утгазүйн холбогдолтой байдаг гэдгийг нь тодосгож, “*чи, та, Ø*” г.м.–ээр хоёрдугаар биеийг заасан төлөөний үг–өгүүлэгдэхүүн нь ихэвчлэн давхар орлон гарсан байгаа нь сонин зүй тогтол юм. Энэ нь мөн л эх ба төгс өгүүлбэрийн мэдээллийн бүтцийн талаасаа онцолбортой холбоотой асуудал юм. Үүнийг мөн тодосгогч давхар гишүүн гэж үзэж болно.

Жич тэмдэглэхэд, монгол хэлний хандсан үгийн бас нэгэн сонин онцлог бол гол төлөв өгүүлэгч биеэс буюу 1-р биеэс 2-р биед хандсан, дуудсан хамаатах харьцаа байдаг учраас 1-р биеэс 1-р биед хандах нь шугаман бус харьцааных байдаг. Ийнхүү 2-р биед хандсан байтлаа 2-р биеийн хамаатах харьцааг ялгах тэмдэг болдог **-чинь** гэдэг хэлбэр илэрдэггүй харин 1-р биеийн хамаатах харьцааны тэмдэг **-минь, -аа** (Бат *аа*,... Бат *минь*,... г.м.-ээр) хоёрын аль нэгээр илэрдэг нь сонин зүй тогтол юм. Энэ бол хандсан үг нь 1-р биеийн хамаатлын **-минь, -аа** гэсэн тэмдэгтэй боловч харилцагч 2-р биед ханддаг болохыг нь тодосгож, (Б-1-10) жишээ баримтад: *Дамбадорж оо, чи...*, *Дүү минь, чи...*, *Чанцаал, чи...*, *Хүү минь, чи...*, *Эгшигт эх ээ, та...*, *Хөгшөөн, чи...*, *Ээж минь, та...* г.м.-ээр 2-р биеийн төлөөний үг давхарлан гарч ирснийг харуулж байна. Харин бүтэц өгүүлбэрийн өгүүлэхүүн нь бие зааж илрэхдээ 1-р биеэр төгсгөх нөхцөлөөр хэлбэржсэн байвал, тийм хүсэл зоригийн утгатай өгүүлбэрт хандсан үг нь субъектын холбогдолтой байж чадахгүй байгаа юм. Жишээ нь:

Морьтон ардын гучин гурван *уудам минь*,

Монгол газрын гучин гурван *говь минь*,

Таныгаа би гурван гурав ес *тойрьё*,

Тахь, хулан ээлжлэн унаж, ес *тойрьё*. (Т.Галсан) г.м.

Хандсан үгтэй захирах хүсэх өгүүлбэр нь **"та, чи"** г.м.-ээр 2-р бие заасан хэлзүйн өгүүлэхүүн нь илт гарсан байхаас гадна ерөөс хандсан үгтэйгээ давхцан тодорхой эзэн болж, **"Ø-тэг"**-ээр гарах зүй тогтол ч монгол хэлэнд бий. Үүнийг

1. Төрүүлж өсгөсөн гөрөөс *ээж минь*

Төөрөлдсөн янзага намайгаа өршөө. (Д.Равжаа),

2. *Эхнээр*, аяга цай авчирч өгөөч гэж дуудсанд хариу алга. (Н.Надмид),

Тэмүжин хөвүүнийг даруй явж авчир, *хайрт Мэнлиг минь*. (МНТ),

3. *Хаан анд минь*, өшөө хорсол буцалсан хамгийн бэрх цагт ч

Өэлүн эхийн сүү цусгүй байсныг санагтун! (Д.Намсрай) г.м. өгүүлбэрт: ...гөрөөс ээж минь, *та...*, Хайрт Мэнлиг минь, *чи...*, хаан анд минь, *та*, Эхнээр, *чи...* г.м.-ээр **"та, чи"** г.м. төлөөний үгийг орлуулан ил гаргаж болох үндэстэй байна.

д. (Б-1-10)-д байгаа хандсан үгийг бүгдийг утга үүргээр нь **"идэвхтэй сонсогч хоёрдугаар бие төдийгүй, үйлийг идэвхтэй гүйцэтгэх хоёрдугаар бие"** гэж үзэж болно гэж бодож байна.

е. (Б-1-10)-ын баримтыг ажиглахад, хандсан үг нь бүтэц өгүүлбэрийн субъектыг заасан сэдэх мэдээллийн тэмдэг-шинэ үг болж чадаж байна. Иймээс ч хандсан үгийн тэмдэг болж, бүтэц өгүүлбэрт нь **"чи, та, Ø"** г.м. үйлийг эрхлэгч эзэн бие илт гарч, өгүүлбэрийн найруулга нь өвөрмөц болж, (А) бүлгээс ялгаатай нь тодорхой байна. Энэ тохиолдолд хандсан үг нь үйл, үйлийн эзний идэвхтэй харьцааны дотор илэрдэг гэж үзэж болно.

ё. (Б) бүлэглэлийн хандсан үгс нь ерөнхий ба тусгай шинжээрээ (А) бүлэглэлийнхтэй эсрэгцэх бөгөөд өгүүлбэрийн найруулгын онцлог, хэлэхүйгээс шалтгаалж, бүтэц өгүүлбэрийнхээ эхэнд ч, дунд ч, бас эцэст ч байрлаж болно. Үүнийг жишээлбэл:

Гайхалтай шүү чи, *Хандаа*, гайхалтай

Гарын чинь сайханд алтны сүр дарагдана, *Хандаа*

Ухаантай шүү чи, *Хандаа*, ухаантай

Учиртайхан шиг хэлсэн ганц үг чинь

Ухааныг тэлж, урмыг хөгжөөнө, *Хандаа* (Б.Явуухулан),

- **Охин минь**, өршөөгөөрэй, би чамтайгаа эргэж уулзахаас ичиж байна. **Охин минь...**, **Дунгаамаа минь**, үрийг чинь үнэрлэх хувь ээжид чинь байхгүй ээ. (До.Цэнджав) г.м. олон баримтаар нотолж болно.

ж. (А) ба (Б) хоёр бүлэг жишээний хандсан үгэнд илэрч байгаа **-минь, -аа...**, үе уртасгасан урт эгшиг (Хөгшөөн! Өвгөөн!, Жанжаан! гэдгийн), дуудах, анхааруулах хөг аялга зэргийг **хандсан үгийг таних "тэмдэг"** гэж үзэж болно. **Жич.** (Б) бүлгийн жишээ баримтаас харахад хандсан үг нь сав ба шим ертөнцийн зүйлийн аль аль нь байж болно. Ер нь, **"хандсан үг"** нь эх ба өгүүлбэрийн түвшинд үгийн утга шилжих, амьдчилах, хүнчлэх найруулгын ур маягтай холбоотой байдаг. Монгол хэлний **"хандсан үг"** нь дуудах тийн ялгалаар илрэхдээ амьдчилах, хүнчлэхтэй хэрхэн холбоотойг харж болох тийм сонин хөөрхөн нэг баримт – жишээг академич Ш.Лувсанвандан гуай **"Монгол хэлний зүйн сурах бичиг"** (1956)-ийнхээ **"хөндлөнгийн үг"**-ийн хэсэгт 96-р дасгалын **"Эмгэн, гахай хоёр"** бичил эхэд маш сонирхолтойгоор харуулсан байдаг билээ. Тухайлбал: **Нохой!, Нохой!**, энэ гахайг зуугтун. **Саваа аа!, Саваа аа!** Энэ нохойг цохиоч! **Гал аа!, Гал аа!** Энэ савааг шатаагтун! **Ус аа! Ус аа!** Энэ галыг унтраагаач! **Шар аа! Шар аа!** Энэ усыг уугтун! **Яргачаан! Яргачаан!** Энэ шарыг алагтун! **Олс оо! Олс оо!** Энэ яргачинг боож алагтун! **Хулгана аа! Хулгана аа!** Энэ олсыг мэрэгтүн! **Муур аа! Муур аа!** Энэ хулганыг барьж идээрэй! г.м.

Бидний (В) бүлэглэл буюу өөр нэгэн багц болгож үзэх саналтай байгаа хандсан үг нь, хэлбэр, утга, үүрэг, байрлалаараа (А), (Б) хоёр бүлэглэлээс арай өөр юм. Одоо хэдэн баримт харъя.

(В)

1. Цагийг эрхэндээ оруулж болдоггүй хатуу хуультай хорвоод өнгөрсөнтэй, одоотой, бас ирээдүйтэй явах юутай зол заяа вэ? Уралданхан байдаг **ухаан, цаг хоёр минь!** (С.Эрдэнэ),
2. Зудын хүйтнийг дажгүй давсан
Зусаг, төлөг хоёр минь, баяртай,
Аргаль угалз гэмээр сүртэй
Аргай даргай хуц минь, баяртай (Д.Бямбаа),
3. Хөрстэй алтанхан дэлхий дээгүүр
Хөндөлдөн урсдаг **Сүхээ гол оо** (А.А.З.),
4. Аав ээжийнхээ гэрт адил хүндлүүлсэн найз минь
Айл гэрийнхээ заяанд илч хайрласан **анд минь** (Б.Дашзэгвэ),
5. Холхи газраас гялалзан харагдагч **өнгөт од оо!**
Хязгааргүй огторгуйн дунд зугаалагч олон улаан **оч оо!**
Нарт ертөнцийн дотор суугаа **Марс од оо!**
Манай хүн төрөлхтөн чамтай танилцахыг хэдийнээс хүсэв. (Д.Нацагдорж),
6. Хоёр хүний хийхийг нэгэн биеэр хийсэн,
Хоёр загалын туулахыг нэгэн хөлөөрөө туулсан **сайн нөхөр –Түдэв минь!** (Д.Маам);

(В) 1-6)-ын жишээ баримтаас ямар дүгнэлт хийж болох вэ? гэвэл:

а. (В-1-6)-ын жишээг хэвшинж, байрлал, хэл, хэлэхүйн холбогдол, мэдээлэл, харилцахуйн утга, үүргээрээ (А), (Б) хоёр бүлэглэлийн жишээнээс арай өөр гэж үзэж байна.

б. (В-1-6)-ын жишээнээс харахад, ихэвчлэн хандсан үг нь эцэст нь байрлаж, өөртөө тодотгосон хэллэгтэй байгаа бөгөөд хэллэгээр илрэгч *утгазүйн субъект, хандсан үг хоёр нь давхацсан юм шиг* тийм байдалтай буй нь сонин байна.

в. (В) хэв маягийн өгүүлбэрүүдийг ажиглахад хандсан үг нь тодруулсан үгтэй нэрлэсэн өгүүлбэрээр хандаж, дуудсан байдалтай юм. Энэ дашрамд, ерөөс *хандсан үг нь дэлгэрүүлсэн үгтэй байх хэв маягтай* байгаа өвөрмөц талыг анхаарахгүй байж болохгүй. Тухайлбал,

1. *Их, дээд сургуулийн оюутнууд аа! Манай орны малчид, тариаланчид аа!* гэвэл дэлгэрэнгүй бүтэцтэй хандсан үг болно.

2. *Ерөнхийлөгч өө! Ерөнхий сайд аа!* гэвэл хураангуй хандсан үг болно. Тэгэхлээр (В-1-6) бол дэлгэрэнгүй нэрлэсэн өгүүлбэрийн маягтай хандсан үг ч гэж болмоор байна.

г. (В-1-6)-ын жишээг харахад хандсан үг нь утга, үүргээрээ идэвхтэй сонсогч хоёрдугаар бие болж чадахгүй, *тодруулсан үгтэй, нэг бүрэлдэхүүнт, нэрлэсэн өгүүлбэрийн хэсэг болж хэлэхүй талаасаа онцолбор байдалтай илэрдэг*, ихэвчлэн яруу найргийн найруулгад тохиолдох ба найруулга тэгшитгэх ёстой холбоотой нэг хэрэглүүр болдог зүйл гэж үзмээр байна. Иймээс эх ба өгүүлбэрийн мэдээллийн бүтцэд илүү чухаг үүрэг гүйцэтгэж дүрслэх хэрэглүүрийн үүрэгтэй ч юм шиг байна.

(Г) буюу дөрөвдүгээр хэвшинжийг авч үзье. Энд өвөрмөц зүйл ажиглагдаж байна. Зарим хандсан үг нь яригч, бичигчийн сэтгэлийн хөдөлгөөнийг үлэмж хүчтэй илэрхийлж, маш хийсвэр утга зааж байна. Ийм хандсан үг нь тухайн эх, мөчлөг, цогцолбор, өгүүлбэрийн хэлзүйн ба утгын бүтцэд төдий л холбогдолгүй, мэдээллийн нэмэлт ачаалал ч өгөхгүй, гагцхүү сэтгэлийн хөдөлгөөн, үнэлэмжийн өнгө ялгааг илэрхийлэх гол үүрэгтэй байх шиг байна. Ийм хандсан үгийг *субъектив хандсан үг* гэж нэрлэж болно.

Хэлшинжлэлийн доктор Л.Түдэв гуайн “Эцгийн лимбэ” өгүүллэгийг нэгэнтээ эргүүлж тойруулж байтал “*Хайн Богд оо!* лимбэтэй болох нь уу гэх эцгийн дуу сонсогдов”. “*Хайн богд оо!* тэр бисаанз чинь лимбэнээс хэцүү шүү дээ, хүү минь” г.м. хоёр өгүүлбэртэй тааралдаж, зарим хандсан үг (тухайлбал, *Хайн Богд оо!* г.м.) маш хийсвэр утгатай, яригч, бичигчийн сэтгэлийн хүчтэй хөдөлгөөн, уулга алдсан байдлыг заадгийг анзаарч билээ. Иймэрхүү хандсан үгийг бидний дээр авч үзсэн (А), (Б), (В) бүлэглэлийн хандсан үгээс хэрэглэсэн зорилго, үүрэг, аялга, үнэлэмжийн талаасаа өвөрмөц ялгаатай гэж үзэж болно.

Мөн доктор Х.Нямбуу гуайн бичсэн “Монгол ёс заншлын дунд тайлбар толь” (1991)-ийг сөхөж үзэхэд “Иймээс ч бөөгийн дуудлагад “*Аа, Хайрхаан*” гэсэн үг олонтаа гардаг бөгөөд хүн уулга алдахдаа мөн л “*Хайрханыг*” дуудаж ханддаг болой” (5:37) гэж дурдсан байх юм. Доктор Х.Нямбуу агсны “Өвөөгийн өгүүлсэн түүх” (1990) номд “Настангуудын үргэлж дурсаж хэлдэг “*Төрийн минь сүлд*”, “*Төрийн минь сүлд өршөө*”, “*Өндөр төр минь!*” г.м. хандсан үг байдгийг тэмдэглэсэн байна. Энд дурдаж буй хандсан үгс нь өгүүлэгчийн сэтгэл хөдлөлтэй холбогдож үүссэн хийсвэр утгатай хандсан үг юм.

Ардын төрмөл ухаан, эрдэмтэн мэргэдийн таримал ухаанаас үүдээд бодвол, монгол утга зохиолын хэлэнд хийсвэр утгатай, уулга алдсан шинж, зорилготой хэлдэг хандсан үгийн бүлэг хэв шинж байна. Үүнд холбогдуулж, дараах хэдэн жишээ баримтыг харж, (А), (Б), (В) бүлгийнхтэй харьцуулан зарим дүгнэлт хийж болно. Жишээгээр тайлбарлавал:

1. Тийнхүү бие сэтгэл ихэд хөнгөрөн, мордож давхисаар Ононгийн гарам дээр ирэв. **Онон минь!, Онон минь!** багын амраг шиг сайхныг яана (С. Эрдэнэ),
2. **Ай төрийн минь сүлд!** Цөвүүн цагийн энэ бусармаг явдлуудыг яалтай билээ. (“Бодлын солбицол” сонин),
3. **–Ээ, үр минь, ээ сахиус минь хэмээн,** шүд нь унаж гүйцсэн хулсан савраа тээр тэнд чулуудчихаад гүйж ирэв. (Д.Төрбат)
4. **Ээ орос минь! Гэргий минь!** бидний зам ер өрөвдмөөр хол ч, бас тодхон нь сайхан... (А.Блок)
5. **Ай Далай ээж минь! Далай ээж минь!** Би одоо хүртэл таныгаа захад ирж, хөл тавьж үзээгүй явсандаа өөрийгөө чамлаж сунам. (С.Эрдэнэ),
6. **Ах минь! Хөөрхий ах минь!** Би ганцхан ахтай юм сан. (С.Эрдэнэ)
7. **–Ай хөөрхий хөвч хангай минь, Хорьдол сарьдаг минь,** Хаа холын говь нутгийн цэцэг шиг ариухан дагиныг наддаа хайрлалаа. (До.Цэнджав)
(Г-1-7) хэв маягийн хандсан үгүүдийг ажиглахад:

а. Ийм хэвшинжийн хандсан үг нь харилцахуйн түвшинд сонсогч хоёрдугаар бие ч биш, бүтэц өгүүлбэрийн үйлийг гүйцэтгэх дохиолох хоёрдугаар бие ч болж чадахгүй харин хэлэхүйн “**дагалдах”** утгыг илэрхийлдэг гэж үзэж болох талтай. Бас “...гэж”, “...хэмээн” гэсэн байдлаар (Г-3 жишээг ажигла.) холбоосжиж орвол аялга өгүүлбэрийн шинжтэй болдог гэж үзэв.

б. Гагцхүү өгүүлэгчийн сэтгэлийн хөдөлгөөн, санамсаргүй хандлага буюу уулгалах аяс байдлыг илэрхийлэх утга үүрэгтэй. Үүнийг сайн найруулгатай бичдэг зохиолчийн хэл найруулгаас харвал ой тойнд илүү орох учиртай юм. Чухам үүний учир ардын уран зохиолч С.Эрдэнийн “**Хулан бид хоёр**” бичил эхээс харъя.

-**Ах гуай,** таны морь бэлэн боллоо гэв. Би гайхасхийн,

-Миний морь гэнэ ээ. Би чинь мод унасан... гэтэл охин инээмсэглээд,

-Ээж танд морь явуулсан юм гэв.

-Ээж чинь хэн бэ?

-Хулан.

-Хулан гэнээ! гээд, босон харайтал охин нэг зурвас өгөөд, ичсэн юм шиг бушуухан гарлаа. Сурагч дэвтрийн тал цаасан дээр “**Самшил,** сайн явж байна уу? Уржигдар ирснийг чинь дуулсан. Би охиноороо морь явуулав. Чи үдийн алдад гол дээр очоорой. Нөгөө газраа мартаагүй биз дээ. Би тэнд очоод хүлээж байя” гэж их л хичээнгүйлэн бичжээ. **Ээ тэнгэр минь!** гэж би дуу алдлаа... (С.Эрдэнэ) г.м.

Энэ жишээ бол өгүүлбэрийн мэдэхүүний тал хийгээд өгүүлэгчийн соёлын зан үйл, хэлэхүйн талд, чухам ямар нөхцөл бүрдсэн үед монгол хүн, “**Ээ тэнгэр минь!**” гэсэн байдлаар дуу алдаж, уулгалсан хандсан үгийг хэрэглэдгийг харуулсан тод баримт болж чадах билээ.

в. Хүмүүсийн танин мэдэх чадвар, зан заншил, сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх хувийн зан үйл, улс үндэстний өвөрмөц онцлог зэрэгтэй холбоотой болох нь харагдаж байна. Ер нь хандсан үг бол цэвэр хэлшинжлэлийн судлагдахуун биш бөгөөд сэтгэц-хэлшинжлэл, нийгэм-хэлшинжлэл, танин мэдэхүйн хэлшинжлэлийн учир холбогдолтой, уламжлал шинэчлэл ба хувиран улирч ирсэн байдал нь монгол хүмүүний танин мэдэхүйн өсөлт, соёлын харилцаа, угсаатны зүй, зан ааль, эерүүлэх, цээрлэх ёсон, мөнх тэнгэрийн үзэл, сүслэн дээдлэх, шүтэн бишрэх зүйлтэй нь ч холбоотой, олон талтай асуудал гэдэг нь одоо тодорхой болж байна.

Өдгөө цагт бас хүмүүсийн нийгмийн сэтгэлзүй, соёлын хандлагыг дагаж хандлагын хэлбэр, зорилго хувиран өөрчлөгдсөөр байгааг анхаарах нь зүйтэй юм.

Эцэст нь, харилцахуйн үйлд оролцож буй биесийн (өгүүлэгч-сонсогч, бичигч-уншигч, зуучлагч г.м.) угсаа гарвал, зан үйл, ажил алба, боловсрол мэргэжил, нас, хүйс, соёлын ялгаа, үндэсний уламжлал, шашин шүтлэг, нийгмийн байдал зэргээс хамаарч, хэнээс хэнд, хэн нь хэнийг, хэн нь хэнтэй, хэн нь хэнээр, хэн нь хэн рүү хандах, ямар нэгэн зүйлийн хүсэл зоргийг илэрхийлэн: **сануулах зөвлөх** (советовать), **батлах, нутлах гэрчлэх** (засвидетельствовать), **амлах, ам өгөх** (обещать), **занах, сүрдүүлэх заналхийлэх** (грозить), **магтах сайшаах** (хвалить), **шоолох элэглэх** (насмехаться), **тайтгаруулах, тайвшруулах** (утешать), **хүсэх, эрмэлзэх** (желать), салах (ёс) хийх, үдэх (прощаться), **гэмшлээ илэрхийлэх** (сожелать), **айлгах, тушаах** (повелевать), **хориглох, цээрлэх** (запрещать), **өргөдөл гаргах, хүсэлт гаргах** (прошения просить), **гашуудах, уйлах** (оплакивать), **гомдоллох** (жаловаться), **хүсэх, гуйх** (просить), **тайлбарлах** (толковать), **баяр хүргэх** (поздравлять) гэх зэрэг үгс нь “**үйл явдал**”, “**хэрэг явдал**”-ыг амьд үнэлэмжтэй болгож, хандлагын ур маягийг бүтээдэг үгсийн сан-утгазүйн тулгуур нь болдгийг онцлон тэмдэглэе.

Номзүй

1. М.Базаррагчаа, Монгол хэлний энгийн өгүүлбэр, Уб., 1993.
2. Орчин цагийн монгол хэлзүй (хамтын бүтээл), Уб., 1966.
3. Ш.Лувсанвандан, Монгол хэлний зүйн сурах бичиг, дэд дэвтэр, үгүүлбэрийн зүй, Уб., 1956.
4. Ш.Барайшир, Б.Пүрэв-Очир, бусад, Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй, Уб., 1989.
5. Х.Нямбуу, Монгол ёс заншлын дунд тайлбар толь, Уб., 1991.
6. Б.Пүрэв-Очир, Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй, хоёрдугаар дэвтэр, нэмсэн хоёр дугаар хэвлэл, Уб., 2000 он.
7. Русский язык, Энциклопедия, глав.редактор Ф.П.Филин, Москва, 1979.
8. Языкознание, “Большой энциклопедический словарь”, главный редактор В.Н.Ярцева, Москва, 1998.
9. Н.А.Николина, Филологический анализ текста, Москва, 2003.
10. Современный русский язык. (Фонетика, лексикология, словообразование, морфология, синтаксис, пунктуация), Под общей редакцией Л.А.Новикова, Санкт-Петербург, 2001.
11. Ц.Сүхбаатар, Монгол хэлний найруулгазүй, Нэмэн зассан дөрөвдүгээр хэвлэл, Уб., 2004 он.
12. Н.Б.Мечковская, Общее языкознание, Структурная и социальная типология языка, Флинта-Наука, М., 2001.

SUMMARY

In this article, the author studied the syntax of tendency words in Mongolian. Tendency words in text show various characteristics.